

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2018 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

**“Шинэ эхлэл” лаборатори сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

**Агуулга**

1. Аудитын гэрчилгээ .....	3-4
2. Аудитын тайлан .....	5
2.1 Оршил .....	5
2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	5
2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	6
2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагааны, хууль, эрх зүйнорчин .....	6
2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	7
2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	7
2.7 Материаллаг байдлын суурь сонгосо үндэслэл, тайлбад .....	8
2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	8
2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	9
2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	9
2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	9
2.11 Шилэн дансны мэдээлэл .....	10
2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	10
2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	10
3. Менежментийн захидал .....	11
3.1 Тооллогын талаар .....	12
3.1.1 Илрүүлэлт: .....	12
3.1.2 Эрсдэл: .....	12
3.1.3 Өгсөн зөвлөмж: .....	12
3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: .....	12
3.2 Томилолтын тооцооны талаар .....	12
3.2.1 Илрүүлэлт: .....	12
3.2.2 Эрсдэл: .....	12
3.2.3 Өгсөн зөвлөмж: .....	12
3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: .....	12
4. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	13
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	13-14
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	15-17
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	18-20
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	21
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	22-24

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт

“Шинэ эхлэл” лаборатори сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

2019.02.25 № 06/231  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

“ШИНЭ ЭХЛЭЛ” ЛАБОРАТОРИ  
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН  
ҮҮРГИЙГ ТҮР ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ  
Н.ОЮУНГЭРЭЛ ТАНАА

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “Шинэ эхлэл” лаборатори сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

“Шинэ эхлэл” лаборатори сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Шинэ эхлэл” лаборатори сургуулийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10.20\Bichig\_Kheregl\Yawsan\_Bichig\2019\0224\SAG20.Docx

070516

“Шинэ эхлэл” лаборатори сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлсэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц НАРАНЧИМЭГ

## 2 АУДИТЫН ТАЙЛАН

### 2.1 ОРШИЛ

“Шинэ эхлэл” лаборатори сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус сургуулийн захирлын үүргийг түр хавсран гүйцэтгэгч Н.Оюунгэрэл танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### 2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “Шинэ эхлэл” лаборатори сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

“Шинэ эхлэл” лаборатори сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 01 дүгээр сарын 25-ны өдрөөс 2019 оны 02 дугаар сарын 16-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг мөн сарын 18-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн Үндэсний аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Лидер экаунт аудит” ХХК-ний аудитын баг хариуцаж хэрэгжүүлэв.

“Шинэ эхлэл” лаборатори сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Санхүүгийн аудитын газарт 2019 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 02/01 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

**“Шинэ эхлэл” лаборатори сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

### **2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### **2.4 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

"Шинэ эхлэл" лаборатори сургуулийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

"Шинэ эхлэл" лаборатори сургууль нь "Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн үнэт зүйл бүхий хүмүүнлэг Монгол иргэнийг төлөвшүүлэх" гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 179 дүгээр тогтоолоор "Шинэ эхлэл" лаборатори сургуулийг байгуулж, үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Монгол Улсын бүрэн дунд боловсролын томоохон шинэчлэл болох олон улсад нийтлэг хүлээн зөвшөөрөгдсөн Кембрижийн их сургуулийн дэргэдэх Олон улсын Үнэлгээний төвийн гаргадаг сургалтын хөтөлбөр, үнэлгээний нэгдмэл үйлчилгээг Монгол Улс боловсролын тогтолцоондоо нэвтрүүлж, харилцан судалж хос хэлний хөтөлбөртэй сургуулийг байгуулж, сурагч, багш, сургуулийн оролцдог үнэлгээ, түүний батламж нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, сурагч ирээдүйд эзэмших мэргэжил сонирхолдоо тулгуурлан хичээлээ, хөтөлбөрөө, шалгалтын даалгавраа сонгодог уян хатан сонголт, сургуулийн хөгжил, удирдлага зохион байгуулалт нь шинэлэг бөгөөд судалгаанд тулгуурласан шийдвэртэй гэдгээрээ нэлээдгүй онцлог юм.

## “Шинэ эхлэл” лаборатори сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

"Шинэ эхлэл" лаборатори сургуулийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

"Шинэ эхлэл" лаборатори сургуулийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Боловсролын тухай хууль
- Бага, дунд боловсролын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй болно.

### **2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус сургуулийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

"Шинэ эхлэл" лаборатори сургуулийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд аудитад мэдээллийн технологийн мэргэжилтнийг татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

"Шинэ эхлэл" лаборатори сургуулийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "ACOLOUS" програм хангамж ашигладаг байна.

"Шинэ эхлэл" лаборатори сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### **2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд

**“Шинэ эхлэл” лаборатори сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 3 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 3 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын 1 хувиар сонгов.

Материаллаг байдлын суурь үзүүлэлтийг нийт зардлаар сонгох нь зохимжтой гэж үзэв.

“Шинэ эхлэл” лаборатори сургуулийн 2018 оны нийт зардал 988,734.7 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 9,887.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Төсөвт байгууллагад санхүүгийн тайланг баталгаажуулах аудитын үед голчлон төсөвт хөрөнгийн зарцуулалтыг авч үзэх учраас материаллаг байдлын түвшинг нийт зардлын 1 хувиар тооцсон.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## **2.8 АУДИТЫН ЯВЦАД ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 3 чиглэлээр аудитын 5 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 2 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 3 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийгээгүй.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.



**“Шинэ эхлэл” лаборатори сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

№	Шийдэл	Тоо	Дүн	/мянган төгрөгөөр/
				Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	2	6,999.6	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0	
3	Албан шаардлага өгсөн	0	0	
<b>Дүн</b>		<b>2</b>	<b>6,999.6</b>	

### 2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулав.

### 2.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал гараагүй болно.

### 2.10 ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

"Шинэ эхлэл" лаборатори сургуулийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбогдон 2018 онд 959,084.8 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 878,785.3 мянган төгрөг байгаа нь батлагдсан төсвийг 80,299.5 мянган төгрөгөөр буюу 8.3 хувиар хэмнэлттэй зарцуулсан.

### 2.11 Шилэн дансны мэдээлэл

"Шинэ эхлэл" лаборатори сургууль Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллага төсвийн орлого, зарлага түүний хэмнэлт хэтрэлтийг сар бүр, 5,000.0 мянган төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээлэл, цалингийн зардлаас бусад 5,000.0 мянган төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээг хуулийн хугацаанд мэдээлж ирсэн байна.

“Шинэ эхлэл” лаборатори сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар төлбөр барагдуулах акт, зөрчил арилгуулах тухай албан шаардлага, урамшуулалын талаар зөвлөмж өгсөнийг хэрэгжүүлж ажилласан байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

**2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид "Шинэ эхлэл" лаборатори сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

"Шинэ эхлэл" лаборатори сургуулийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### 3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь "Шинэ эхлэл" лаборатори сургуулийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### 3.1 Тооллогын талаар

##### 1. Илрүүлэлт:

Тус сургууль нь 2018 оны жилийн эцсийн тооллогыг тооцоо бодсон актаар баталгаажуулаагүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 зүйлийн 4-т "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх" гэсэн заалтыг мөрдөөгүй байна.

##### 2. Эрсдэл:

Хууль тогтоомж, зөрчигдөх эрсдэлтэй.

##### 3. Өгсөн зөвлөмж:

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4 дэх заалтыг мөрдөж ажиллах.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2019 оны 6 дугаар сарын 30-ны дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэх.

“Шинэ эхлэл” лаборатори сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

**3.2 Томилолтын тооцооны талаар**

1. Илрүүлэлт:

Томилолтын тооцоог хийхдээ мөнгөн урьдчилгааны тайлангаар тооцоо хийгээгүй байна. Энэ нь Сангийн сайдын 2017 оны 12 дугаар 05-ны өдрийн 347 дугаар тушаалаар батлагдсан мөнгөн урьдчилгааны тайлан хөтлөх зааврыг мөрдөж ажиллаагүй байна.

2. Эрсдэл:

Санхүүгийн тайланд гүйцэтгэлийн үр дүн буруу илэрхийлэгдэх эрсдэлтэй.

3. Өгсөн зөвлөмж:

Зөрчлийг давтан гаргахгүй байх.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2019 оны 6 дугаар сарын 30-ны дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэх.

4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

**“Шинэ эхлэл” лаборатори сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

**4.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>131,150,939.62</u></b>	<b><u>143,491,248.08</u></b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>131,150,939.62</b>	<b>143,491,248.08</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	78,819,030.00	79,660,706.00
35110	Тусгай зориулалттай материал	76,619,030.00	77,282,706.00
35130	Эм боох материал	2,200,000.00	2,378,000.00
35200	Дуусаагүй үйлдвэрлэл		
35300	Бэлэн бүтээгдэхүүн		
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>52,331,909.62</b>	<b>63,830,542.08</b>
35410	Бичиг хэргийн материал	4,359,081.28	4,723,899.28
35420	Аж ахуйн материал	26,142,504.64	34,136,150.10
35430	Сэлбэг хэрэгсэл		
35440	Түлш, шатах тослох материал	1,473,323.80	4,613,492.80
35450	Барилгын засварын материал		
35460	Хүнсний материал		
35470	Бусад хангамжийн материал	20,356,999.90	20,356,999.90
35500	Биологийн хөрөнгө		
35600	Мал амьтад		
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>1,324,865,140.25</u></b>	<b><u>1,666,659,597.14</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,324,865,140.25	1,666,659,597.14
391	Газар		
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,324,736,807.00	1,666,600,013.93
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,230,400,000.00	1,439,703,470.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-104,242,222.25	00.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	60,800,000.00	60,800,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-41,208,888.72	-51,342,222.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	257,710,511.16	270,030,213.24
39206	Хуримтлагдсан элэгдэл	-219,175,095.38	-183,807,962.46
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	138,458,817.32	128,823,738.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-79,096,034.13	-79,199,976.85
39217	Ном	81,089,719.00	81,592,754.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>128,333.25</b>	<b>59,583.21</b>
39301	Програм хангамж	825,000.00	825,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-696,666.75	-765,416.79
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>1,456,016,079.87</u></b>	<b><u>1,810,150,845.22</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>00.00</u></b>	<b><u>00.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>		
<b>413</b>	<b>Өглөг</b>		
41310	Ажилчидтай холбогдсон өглөг		
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>1,456,016,079.87</u></b>	<b><u>1,810,150,845.22</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,456,016,079.87	1,810,150,845.22

**“Шинэ эхлэл” лаборатори сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,655,454,175.78	1,655,454,175.78
51101	Өмч: - төрийн	1,655,454,175.78	1,655,454,175.78
51102	- хувийн		
51103	- хувьцаат		
51106	Эздийн өмчийн бусад хэсэг		
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>-199,438,095.91</b>	<b>-179,355,689.49</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	-199,438,095.91	-199,438,095.91
51220	Тайлант үеийн үр дүн		20,082,406.42
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	00.00	334,052,358.93
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>1,456,016,079.87</u></b>	<b><u>1,810,150,845.22</u></b>

**“Шинэ эхлэл” лаборатори сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

**4.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН**

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>901,775,890.64</b>	<b>1,008,817,092.68</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>43,739,385.64</b>	<b>17,586,684.46</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>		914,550.00
120009	Бусад орлого		914,550.00
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	43,739,385.64	16,672,134.46
122001	Хандив тусламж /дотоод/	43,739,385.64	16,672,134.46
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>858,036,505.00</b>	<b>991,230,408.22</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	843,545,600.00	959,084,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	843,545,600.00	959,084,800.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	14,490,905.00	32,145,608.22
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		14,817,700.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,490,905.00	17,327,908.22
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>947,051,775.47</b>	<b>988,734,686.26</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>947,051,775.47</b>	<b>988,734,686.26</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	868,620,254.63	887,652,887.51
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>606,020,771.79</b>	<b>634,102,803.00</b>
210101	Үндсэн цалин	332,582,605.79	623,255,260.00
210102	Нэмэгдэл		
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал	273,438,166.00	10,847,543.00
210105	Гэрээт ажлын хөлс		
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/		
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>67,345,647.69</b>	<b>76,433,070.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	44,129,529.69	51,887,712.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,869,890.00	6,323,249.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,740,653.00	4,976,041.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,145,961.00	1,204,187.00
210205	Эрүүл мэндийн даатгал	11,459,614.00	12,041,881.00
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/		
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>25,872,525.71</b>	<b>24,760,035.97</b>
210301	Гэрэл, цахилгаан	11,674,789.00	10,955,586.00
210302	Түлш, халаалт	11,798,816.00	10,605,022.00
210303	Цэвэр, бохир ус	2,398,920.71	3,190,527.97

**“Шинэ эхлэл” лаборатори сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210304	Байрны түрээс		8,900.00
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/		
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>13,800,674.20</b>	<b>30,324,005.81</b>
210401	Бичиг хэрэг	6,440,037.00	4,043,257.00
210402	Тээвэр, шатахуун	1,451,976.20	2,885,731.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,636,401.00	6,111,378.81
210404	Ном, хэвлэл	138,500.00	14,405,404.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	144,000.00	480,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,965,760.00	2,398,235.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	24,000.00	
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>114,000.00</b>	<b>260,000.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	114,000.00	260,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>		<b>68,875.00</b>
210602	Тавилга		68,875.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		
210604	Урсгал засвар		
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,025,000.00</b>	<b>2,999,666.00</b>
210701	Гадаад албан томилолт	00.00	00.00
210702	Дотоод албан томилолт	1,025,000.00	2,999,666.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>13,218,079.99</b>	<b>38,408,924.44</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,053,179.99	35,451,704.44
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	2,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	131,900.00	127,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	829,820.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>141,223,555.25</b>	<b>80,295,507.29</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	31,354,739.56	24,125,770.25
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	109,868,815.69	56,169,737.04
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>78,431,520.84</b>	<b>101,081,798.75</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>		
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг		
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг		
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>78,431,520.84</b>	<b>101,081,798.75</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	18,862,167.00	7,302,000.00



**“Шинэ эхлэл” лаборатори сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,900,000.00	
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>		
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	46,669,353.84	93,779,798.75
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-45,275,884.83</b>	<b>20,082,406.42</b>
<b>145</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>		
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>		
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	11,919,638.32	
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-11,919,638.32</b>	<b>00.00</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-57,195,523.15</b>	<b>20,082,406.42</b>

**“Шинэ эхлэл” лаборатори сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

**4.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>858,036,505.00</b>	<b>992,144,958.22</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>		<b>914,550.00</b>
120009	Бусад орлого		914,550.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>858,036,505.00</b>	<b>991,230,408.22</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	843,545,600.00	959,084,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	843,545,600.00	959,084,800.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>14,490,905.00</b>	<b>32,145,608.22</b>
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	9,000,000.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		14,817,700.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,490,905.00	17,327,908.22
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>858,042,705.00</b>	<b>930,064,053.22</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>858,042,705.00</b>	<b>930,064,053.22</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>779,611,184.16</b>	<b>828,982,254.47</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	606,011,368.92	634,102,803.00
210101	Үндсэн цалин	332,573,202.92	335,564,729.00
210102	Нэмэгдэл	175,879,792.00	167,996,237.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	34,116,659.00	35,851,817.00
210104	Урамшуулал	29,673,103.00	51,338,592.00
210105	Гэрээт ажлын хөлс	33,768,612.00	43,351,428.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>67,345,647.69</b>	<b>76,433,070.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	67,345,647.69	51,887,712.00
210202	Тэтгэмжийн даатгал		6,323,249.00
210203	ҮОМШӨ-ний даатгал		4,976,041.00
210204	Ажилгүйдлийн даатгал		1,204,187.00
210205	Эрүүл мэндийн даатгал		12,041,881.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>25,872,525.71</b>	<b>24,751,135.97</b>
210301	Гэрэл, цахилгаан	11,674,789.00	10,955,586.00
210302	Түлш, халаалт	11,798,816.00	10,605,022.00
210303	Цэвэр, бохир ус	2,398,920.71	3,190,527.97
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>16,056,931.00</b>	<b>22,904,278.81</b>

**“Шинэ эхлэл” лаборатори сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210401	Бичиг хэрэг	3,570,300.00	3,141,100.00
210402	Тээвэр, шатахуун	2,681,900.00	6,017,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,636,401.00	6,111,378.81
210404	Ном, хэвлэл	5,556,000.00	3,497,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	405,000.00	480,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,207,330.00	3,657,600.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>391,500.00</b>	<b>360,000.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	391,500.00	360,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,025,000.00</b>	<b>2,999,666.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,025,000.00	2,999,666.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>23,695,701.28</b>	<b>39,535,624.44</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	22,530,801.28	36,578,404.44
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	2,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	131,900.00	127,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	829,820.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>39,212,509.56</b>	<b>27,895,676.25</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	39,212,509.56	27,895,676.25
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>78,431,520.84</b>	<b>101,081,798.75</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>31,762,167.00</b>	<b>7,302,000.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	18,862,167.00	7,302,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,900,000.00	
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>46,669,353.84</b>	<b>93,779,798.75</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	46,669,353.84	93,779,798.75
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>-6,200.00</u></b>	<b><u>62,080,905.00</u></b>
	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>4</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)</b>		
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>		<b>62,080,905.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>		<b>62,080,905.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>		62,080,905.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		62,080,905.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>		<b><u>-62,080,905.00</u></b>
	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		

“Шинэ эхлэл” лаборатори сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	-6,200.00	
9	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	6,200.00	
10	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		

“Шинэ эхлэл” лаборатори сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**4.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ, ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

/ төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
D01	<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,655,454,175.78</b>		<b>-199,438,095.91</b>		1,456,016,079.87
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,655,454,175.78</b>		<b>-199,438,095.91</b>		1,456,016,079.87
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		334,052,358.93			334,052,358.93
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					
D08	Тайлант үеийн үр дүн			20,082,406.42		20,082,406.42
D09	<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,655,454,175.78</b>	<b>334,052,358.93</b>	<b>-179,355,689.49</b>		<b>1,810,150,845.22</b>

**“Шинэ эхлэл” лаборатори сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

#### 4.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	959,084,800.00	878,785,251.47	80,299,548.53	91.63
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	959,084,800.00	878,785,251.47	80,299,548.53	91.63
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	951,782,800.00	871,483,251.47	80,299,548.53	91.56
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	705,436,100.00	634,102,803.00	71,333,297.00	89.89
210101	Үндсэн цалин	348,542,200.00	335,564,729.00	12,977,471.00	96.28
210102	Нэмэгдэл	201,907,600.00	167,996,237.00	33,911,363.00	83.20
210103	Унаа хоолны хөнгөлөлт	36,960,000.00	35,851,817.00	-1,108,183.00	97.00
210104	Урамшуулал	74,826,300.00	51,338,592.00	23,487,708.00	68.61
210105	Гэрээт ажлын хөлс	43,200,000.00	43,351,428.00	151,428.00	100.35
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	81,094,000.00	76,433,070.00	-4,660,930.00	94.25
210201	Тэтгэврийн даатгал	55,462,600.00	51,887,712.00	-3,574,888.00	93.55
210202	Тэтгэмжийн даатгал	6,407,900.00	6,323,249.00	-84,651.00	98.68
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,126,300.00	4,976,041.00	-150,259.00	97.07
210204	Ажилгүйдлийн даатгал	1,281,600.00	1,204,187.00	-77,413.00	93.96
210205	Эрүүл мэндийн даатгал	12,815,600.00	12,041,881.00	-773,719.00	93.96
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	25,810,900.00	24,751,135.97	-1,059,764.03	95.89
210301	Гэрэл, цахилгаан	11,214,900.00	10,955,586.00	-259,314.00	97.69
210302	Түлш, халаалт	11,195,900.00	10,605,022.00	-590,878.00	94.72
210303	Цэвэр, бохир ус	3,400,100.00	3,190,527.97	-209,572.03	93.84
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	27,789,600.00	26,793,378.81	-996,221.19	96.42
210401	Бичиг хэрэг	3,141,100.00	3,141,100.00		
210402	Тээвэр, шатахуун	4,017,000.00	6,017,000.00	2,000,000.00	149.79
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	17,420,200.00	6,111,378.81	11,308,821.19	35.08
210404	Ном, хэвлэл	112,800.00	7,386,300.00	7,273,500.00	6,548.14
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	480,000.00	480,000.00		100.00

**“Шинэ эхлэл” лаборатори сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,618,500.00	3,657,600.00	1,039,100.00	139.68
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	360,200.00	360,000.00	-200.00	99.94
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	360,200.00	360,000.00	-200.00	99.94
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	50,000,000.00	49,949,161.00	-50,839.00	99.90
210601	Багаж, техник, хэрэгсэл	50,000,000.00	49,949,161.00	-50,839.00	99.90
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	3,000,000.00	2,999,666.00	-334.00	99.99
210702	Дотоод албан томилолт	3,000,000.00	2,999,666.00	-334.00	99.99
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	27,414,500.00	26,285,624.44	-1,128,875.56	95.88
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	24,282,600.00	23,328,404.44	-954,195.56	96.07
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00	0.00	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	00.00	0.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	131,900.00	127,400.00	-4,500.00	96.59
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	1,000,000.00	829,820.00	-170,180.00	82.98
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	30877500.00	29808412.25	-1,069,087.75	96.54
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	30,877,500.00	29,808,412.25	-1,069,087.75	96.54
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	7302000.00	7302000.00		100.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	7,302,000.00	7,302,000.00		100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	7,302,000.00	7,302,000.00		100.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	959,084,800.00	959,084,800.00		100.00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	959,084,800.00	959,084,800.00		100.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	959,084,800.00	959,084,800.00		100.00
<b>122</b>	<b>ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ</b>				
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	48	48		100
620001	Удирдах ажилтан	1	1		100
620002	Гүйцэтгэх ажилтан	31	31		100
620003	Үйлчлэх ажилтан	16	16		100

**“Шинэ эхлэл” лаборатори сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

**4.6 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

<b>Огноо:</b>	<b>Аудитын нэр:</b>	<b>“Шинэ эхлэл” лаборатори сургуулийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</b>	<b>Аудитын код:</b>
2019.02.22			САГ-2019/179/СТА-ТШЗ
<b>Шалгагдсан байгууллагын нэр:</b>	<b>“Шинэ эхлэл” лаборатори сургууль</b>		<b>Мянган төгрөгөөр</b>

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
А	З	4	5	9	10
1	Тус сургууль нь 2018 оны жилийн эцсийн тооллогыг тооцоо бодсон актаар баталгаажуулаагүй байна . Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 зүйлийн 4-т "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх" гэсэн заалтыг мөрдөөгүй байна.		Зөвлөмж	Захирлын үүргийг түр хавсран гүйцэтгэгч	Н.Оюунгэрэл
				Нягтлан бодогч	Д.Наранцэцэг
2	Томилолтын тооцоог хийхдээ мөнгөн урьдчилгааны тайлангаар тооцоо хийгээгүй байна. Энэ нь Сангийн сайдын 2017 оны 12 дугаар 05-ны өдрийн 347 дугаар тушаалаар батлагдсан мөнгөн урьдчилгааны тайлан хөтлөх зааврыг мөрдөж ажиллаагүй байна.	6,999.60	Зөвлөмж	Захирлын үүргийг түр хавсран гүйцэтгэгч	Н.Оюунгэрэл
				Нягтлан бодогч	Д.Наранцэцэг
<b>Дүн</b>		<b>6,999.60</b>			